**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх авто зам засвар, арчлалт ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/009/НА-СТА-ТӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn<br><br>Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн захирал: М.Буянбулган<br>Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/248

танай ______-ны № ______-т

НАЛАЙХ АВТО ЗАМ ЗАСВАР
АРЧЛАЛТ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БАТТУЛГА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайх дүүргийн Налайх Авто зам засвар, арчлалт ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 779,964.6 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг, "Нийцсэн бөгөөд зохистой байх", батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын дагуу өөрчлөн зохион байгуулагдсан "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-ийн дүрэмд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 108 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, тус байгууллагыг охин компанийн хэлбэрээр ажиллуулахаар бүтэц, орон тоог баталж өгсөн боловч шийдвэрлэгдээгүй байна.

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар бүх явцыг санхүүгийн тайланд толилуулж, толилуулаагүй асуудал гараагүй болно.

1425010020

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 591 дүгээр тогтоолоор баталсан компанийн тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 88.5 хувиар биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.03.15 Nalaih АЗЗ.docx.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | 2023-12-31 | 2024-12-31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 9,876,951.58 | 2,424,584.65 |
| 1.1.2 | Дансны авлага | 55,282,520.07 | 58,593,615.29 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 10,965,691.27 | 11,265,691.27 |
| 1.1.4 | Бусад авлага | - | 46,000.00 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| 1.1.6 | Бараа материал | 80,079,809.53 | 65,719,057.63 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал, тооцоо | - | - |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | - | - |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | - | - |
| 1.1.10 | Богино хугацаат хөрөнгө оруулалт | - | - |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **156,204,972.45** | **138,048,948.84** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 1,132,952,954.40 | 1,083,614,588.24 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,628,796,100.00 | 1,631,796,100.00 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | - | - |
| 1.2.4 | Урт хугацаат  хөрөнгө оруулалт | - | - |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | - | - |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| 1.2.9 | Дуусаагүй барилга | - | - |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **2,761,749,054.40** | **2,715,410,688.24** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,917,954,026.85** | **2,853,459,637.08** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 390,918,802.12 | 599,478,312.41 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | - | - |
| 2.1.1.3 | Татварын өр | 517,494,808.89 | 663,809,142.71 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 107,752,175.98 | 111,137,816.77 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | - | - |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | - | - |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | - | - |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | - | - |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | - | - |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр | - | - |
| 2.1.1.12 | Бусад өглөг | - | 263,012.64 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,016,165,786.99** | **1,374,688,284.53** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | - | - |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | - | - |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | - | - |
| 2.1.2.5 | | - | - |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,016,165,786.99** | **1,374,688,284.53** |
| **2.3** | **Эздийн өмч** | **862,884,484.18** | **839,162,304.18** |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 862,884,484.18 | 839,162,304.18 |
| 2.3.2 | - хувийн | - | - |
| 2.3.3 | - хувьцаат | - | - |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | - | - |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,980,538,880.85 | 1,980,538,880.85 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | - | 19,147,763.33 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (552,095,434.08) | (941,635,125.18) |
| 2.3.10 | Тайлант үеийн ашиг (алдагдал) | (389,539,691.09) | (418,442,470.63) |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **1,901,788,239.86** | **1,478,771,352.55** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **2,917,954,026.85** | **2,853,459,637.08** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | 2023-12-31 | 2024-12-31 |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 3,014,513,527.81 | 2,183,985,585.52 |
| 2 | Борлуулалтын өртөг | 3,045,729,836.85 | 2,154,097,687.51 |
| **3** | **Нийт ашиг ( алдагдал)** | **(31,216,309.04)** | **29,887,898.01** |
| 4 | Түрээсийн орлого | - | - |
| 5 | Хүүний орлого | - | 365,860.60 |
| 6 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 8 | Бусад орлого | 431,715.25 | - |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 46,471,267.76 | - |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 312,283,829.54 | 448,659,643.18 |
| 11 | Санхүүгийн зардал | - | - |
| 12 | Бусад зардал | - | - |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| 17 | Бусад ашиг алдагдал | - | - |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)** | **(389,539,691.09)** | **(418,405,884.57)** |
| 19 | Орлогын татварын зардал | - | 36,586.06 |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(389,539,691.09)** | **(418,442,470.63)** |
| **21** | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **(389,539,691.09)** | **(418,442,470.63)** |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | **-** | **-** |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| **24** | **Орлогын нийт дүн** | **(389,539,691.09)** | **(418,442,470.63)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | **2022-12-31-ний үлдэгдэл** | **862,884,484.18** | - | **1,980,538,880.85** | | - | **(489,175,756.87)** | **16,282,258.40** |
| 2 | НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | | | | - | (62,919,677.23) | (62,919,677.23) |
| **3** | **Залруулсан үлдэгдэл** | **862,884,484.18** | - | **1,980,538,880.85** | - | - | **(552,095,434.10)** | **2,291,327,930.93** |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | | (389,539,691.09) | (389,539,691.09) |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | - | - | - | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - | - |
| **1** | **2023-12-31-ний үлдэгдэл** | **862,884,484.18** | - | **1,980,538,880.85** | - | - | **(941,635,125.19)** | **1,901,788,239.84** |
| 2 | НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | | | - | 0.0 | 0.01 |
| **3** | **Залруулсан үлдэгдэл** | **862,884,484.18** | - | **1,980,538,880.85** | - | - | **(941,635,125.18)** | **1,901,788,239.85** |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | | (418,442,470.63) | (418,442,470.63) |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | (23,722,180.00) | - | - | - | 19,147,763.33 | - | (4,574,416.67) |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - | - |
| **9** | **2024-12-31-ний үлдэгдэл** | **839,162,304.18** | - | **1,980,538,880.85** | - | **19,147,763.33** | **(1,360,077,595.81)** | **1,478,771,352.55** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | 12/31/2023 | 12/31/2024 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **3,612,943,284.14** | **2,401,589,760.55** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 3,122,086,629.23 | 2,321,155,429.05 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | 1,201,418.00 |
| | Буцаан авсан албан татвар | - | - |
| | Татаас, санхүүжилтийн орлого | - | - |
| | Бусад мөнгөн орлого | 490,856,654.91 | 79,232,913.50 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **3,561,651,933.38** | **2,367,896,181.08** |
| | Ажиллагчдад төлсөн | 809,964,481.48 | 584,125,604.00 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 202,300,000.00 | 169,326,840.45 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 1,965,131,821.42 | 591,604,561.00 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 9,538,862.00 | 51,552,458.45 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 371,109,830.00 | 668,112,135.00 |
| | Хүүний төлбөрт төлсөн | 622,876.36 | 31,726.62 |
| | Татварын байгууллагад төлсөн | 48,630,903.75 | 80,529,679.22 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | - | 564,080.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 154,353,158.37 | 222,049,096.34 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **51,291,350.76** | **33,693,579.47** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **431,715.25** | **365,860.60** |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| | Хүлээн авсан хүүний орлого | 431,715.25 | 365,860.60 |
| | бусад | - | - |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **-** | **23,964,970.00** |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 23,192,800.00 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | 772,170.00 |
| | Бусад | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **431,715.25** | **(23,599,109.40)** |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **-** | **-** |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| | Төрөл бүрийн хандив | - | - |
| | Бусад | - | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 70,013,000.00 | 17,546,837.00 |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 70,013,000.00 | 17,546,837.00 |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | - | |
| | Төлсөн ногдол ашиг | - | - |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | (70,013,000.00) | (17,546,837.00) |
| | **Валютын ханшийн зөрүү** | **-** | **(0.00)** |
| 4 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(18,289,933.99)** | **(7,452,366.93)** |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **28,166,885.57** | **9,876,951.58** |
| 6 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **9,876,951.58** | **2,424,584.65** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ төгрөгөөр/

| № | Үзүүлэлтүүд | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Зөрүү хувиар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Зам засвар арчлалтын ажил | 2,307,272,720.00 | 1,590,839,448.17 | 716,433.3 | 68.9 |
| 2 | Машин механизмын орлого | 90,909,090.00 | 76,227,499.20 | 14,681,590.80 | 83.9 |
| 3 | Тохижилт болон бусад орлого | | 438,893,326.36 | (438,893,326.36) | |
| 4 | Бусад орлого | 45,454,550.00 | 78,391,172.39 | (32,936,622.39) | 172.5 |
| 5 | **Нийт орлого** | **2,443,636,360.00** | **2,184,351,446.12** | **259,284,913.88** | 89.4 |
| 6 | Үндсэн ба нэмэгдэл цалин | 489,928,000.00 | 437,484,428.92 | 52,443,571.08 | 89.3 |
| 7 | Нийгмийн даатгалын шимтгэл | 71,039,500.00 | 58,015,619.95 | 13,023,880.05 | 81.7 |
| 8 | Түүхий эд материал | 755,000,000.00 | 776,267,536.29 | (21,267,536.29) | 102.8 |
| 9 | Тос тосолгоо | 15,000,000.00 | 5,936,220.47 | 9,063,779.53 | 39.6 |
| 10 | Шатахуун | 110,700,000.00 | 161,928,738.91 | (51,228,738.91) | 146.3 |
| 11 | Сэлбэг хэрэгсэл | 30,000,000.00 | 43,533,967.69 | (13,533,967.69) | 145.1 |
| 12 | Дулаан уур ус | 7,500,000.00 | - | 7,500,000.00 | - |
| 13 | Цахилгаан | 6,500,000.00 | - | 6,500,000.00 | - |
| 14 | Тээвэр, бэлтгэл ажиллагаа | 80,000,000.00 | 107,912,490.51 | (27,912,490.51) | 134.9 |
| 15 | Хөдөлмөр хамгааллын зардал | 35,000,000.00 | - | 35,000,000.00 | - |
| 16 | Томилолт /хээрийн нэмэгдэл | 25,000,000.00 | 42,437,997.20 | (17,437,997.20) | 169.8 |
| 17 | Холбоо бичиг хэрэг | 3,000,000.00 | 155,909.09 | 2,844,090.91 | 5.2 |
| 18 | Урсгал засвар | 25,000,000.00 | 4,948,727.27 | 20,051,272.73 | 19.8 |
| 19 | Машин механизмын түрээс | 90,000,000.00 | 235,542,727.27 | (145,542,727.27) | 261.7 |
| 20 | Үндсэн хөрөнгийн элэгдэл | 80,000,000.00 | 50,137,306.61 | 29,862,693.39 | 62.7 |
| 21 | Бусад зардал | 6,500,000.00 | 7,828,373.84 | (1,328,373.84) | 120.4 |
| 22 | Газрын төлбөр | 23,000,000.00 | 120,000.00 | 22,880,000.00 | 0.5 |
| 23 | Ажилчдын эрүүл мэнд, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөн зориулах | 10,000,000.00 | 1,182,272.73 | 8,817,727.27 | 11.8 |
| 24 | Сургалтын зардал | | 13,778,181.82 | (13,778,181.82) | |
| 25 | Тэтгэвэр тэтгэмжийн зардал | | 14,500,000.00 | (14,500,000.00) | |
| 26 | Найдваргүй авлагын зардал | | 14,825,950.00 | (14,825,950.00) | |
| 27 | Бэлэг дурсгал | | 2,070,000.00 | (2,070,000.00) | |
| 28 | Хандив | | 500,000.00 | (500,000.00) | |
| 29 | Торгууль | | 500,000.00 | (500,000.00) | |
| 30 | Тээврийн хэрэгслийн татвар оношлогоо | 5,000,000.00 | 5,152,645.50 | (152,645.50) | 103.1 |
| 31 | Ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэх | 15,000,000.00 | 500,000.00 | 14,500,000.00 | 3.3 |
| 32 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | | 125,596,008.39 | (125,596,008.39) | |
| | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | | 43,242,585.04 | (43,242,585.04) | |
| 33 | **Үйлдвэрлэлийн зардал** | **1,883,167,500.00** | **2,154,097,687.50** | **(270,930,187.50)** | 114.4 |
| 34 | Үндсэн ба нэмэгдэл цалин | 285,265,000.00 | 277,108,810.52 | 8,156,189.48 | 97.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | НДШ | 49,019,400.00 | 33,649,556.95 | 15,369,843.05 | 68.6 |
| 36 | Унаа хоолны болон бусад хөнгөлөлт | 52,800,000.00 | - | 52,800,000.00 | - |
| 37 | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 35,000,000.00 | 12,070,694.18 | 22,929,305.82 | 34.5 |
| 38 | Цахилгаан | 4,500,000.00 | - | 4,500,000.00 | - |
| 39 | Халаалт | 7,000,000.00 | 13,264,015.95 | (6,264,015.95) | 189.5 |
| 40 | Унааны зардал | 10,000,000.00 | - | 10,000,000.00 | - |
| 41 | Гадаад дотоод томилолт | 3,000,000.00 | 294,581.82 | 2,705,418.18 | 9.8 |
| 42 | Шуудан холбоо | 2,500,000.00 | 241,000.00 | 2,259,000.00 | 9.6 |
| 43 | Хөдөлмөр хамгааллын зардал | 8,000,000.00 | - | 8,000,000.00 | - |
| 44 | ТУЗ зардал /Цалин, Бичиг хэрэг гэх мэт/ | 65,420,000.00 | 52,411,052.73 | 13,008,947.27 | 80.1 |
| 45 | Хэвлэл мэдээлэл зар сурталчилгааны зардал | 3,500,000.00 | 4,562,321.82 | (1,062,321.82) | 130.4 |
| 46 | Бичиг хэрэг /компьютер техник хэрэгслийн материал | 3,500,000.00 | 288,136.36 | 3,211,863.64 | 8.2 |
| 47 | Баяр ёслолын арга хэмжээний зардал | - | - | - | |
| 48 | Тэтгэвэр тэтгэмжийн зардал | 6,000,000.00 | 14,072,142.22 | (8,072,142.22) | 234.5 |
| 49 | Шагнал урамшуулал | 2,500,000.00 | 3,300,000.00 | (800,000.00) | 132.0 |
| 50 | Аудит болон хууль зүй | 3,636,400.00 | - | 3,636,400.00 | - |
| 51 | Сургалт | 2,500,000.00 | 1,600,000.00 | 900,000.00 | 64.0 |
| 52 | Менежментийн зардал | - | - | - | |
| 53 | Ашиглалт болон засвар үйлчилгээ | 6,500,000.00 | 1,204,909.09 | 5,295,090.91 | 18.5 |
| 54 | Газрын төлбөр | - | 23,996,544.00 | (23,996,544.00) | |
| 55 | Тээврийн хэрэгслийн татвар оношлогоо | - | 251,895.18 | (251,895.18) | |
| 56 | Шатахууны зардал | - | 4,006,145.09 | (4,006,145.09) | |
| 57 | Бусад зардал | - | 6,337,837.27 | (6,337,837.27) | |
| 58 | Оффисын ажилчдын ажиллах нөхцөлөөр хангах зардал | 2,000,000.00 | - | 2,000,000.00 | - |
| **59** | **Удирдлагын зардлын дүн** | **552,640,800.00** | **448,659,643.18** | **103,981,156.82** | 81.2 |
| 60 | **Нийт зардал** | **2,435,808,300.00** | **2,602,757,330.68** | **(166,949,030.68)** | 106.9 |
| 61 | Татварын өмнөх ашиг (+), алдагдал (-) | 7,828,060.00 | (418,405,884.56) | 426,233,944.56 | |
| 62 | Орлогын татварын зардал | 782,806.00 | 36,586.06 | 746,219.94 | 4.7 |
| **63** | **Цэвэр ашиг (+), алдагдал (-)** | **7,045,254.00** | **(418,442,470.62)** | **425,487,724.62** | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 54.7 сая төгрөгийн алдаа[1] илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Нийт 780.0 сая төгрөгийн зөрчил[2] илэрч, 2.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 578.5 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 198.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайлангийн өр төлбөрийн үлдэгдэл нь ерөнхий дэвтрийн дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн | 1 | 54.7 | | | | | 1 | 54.7 | | | | |
| | 1 | 54.7 | | | | | 1 | 54.7 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 'Нийгмийн даатгалын тайланд тэтгэврийн насны ажилтны цалинг дутуу тайлагнасан байна. | 1 | 0.6 | | | | | 1 | 0.6 | | | | |
| Нийт 21 хөрөнгийн элэгдлийг дутуу, 92 хөрөнгийн элэгдлийг огт байгуулаагүй байна. | 1 | 124.4 | | | 1 | 124.4 | | | | | | |
| НББОУС 12 "Орлогын албан татвар"-т заасны дагуу хүлээн зөвшөөрвөл зохих хойшлогдсон татварын өр төлбөрийг бүртгээгүй байна. | 1 | 198.1 | | | | | 1 | 198.1 | | | | |
| Ажилтанд цалин, цалингийн нэмэгдэл, урамшуулал, хоолны унааны мөнгийг зөрүүтэй тооцоолж илүү олгосон. | 1 | 1.4 | 1 | 1.3 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Торгуулийг байгууллагаас төлж, буруутай этгээдээс суутган тооцоо хийгээгүй. | 1 | 1.1 | 1 | 1.1 | | | | | | | | |
| НӨАТ-ын тайланд орлогыг тайлагнаагүйгээс татварыг дутуу төвлөрүүлсэн. | 1 | 0.4 | 1 | 0.4 | | | | | | | | |
| Бараа ажил үйлчилгээний худалдан авалтад хууль, журмыг мөрдлөг болгоогүй. | 1 | 454.1 | | | 1 | 454.1 | | | | | | |
| Эдийн засгийн зорилтот түвшнийг бодитой төлөвлөж батлуулаагүй. | 1 | | | | | | 1 | - | | | | |
| Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй. | 1 | | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 9 | **780.1** | 3 | 2.8 | 2 | 578.5 | 4 | 198.7 | | | | |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулсан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн аудиттай холбоотой 1 зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроосон,2 мэдээллийг мэдээлээгүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Нийт дүн | 1 | - | | | | | 1 | - | | | | |

## 5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТБОНӨҮГ | 1 | 1 | | | | 1 | | |
| | | | | | | | | | |
| | **НИЙТ** | 1 | 1 | | | | 1 | | |